

Төлөвлөгөөг баталсан:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ



Л.БЯМБАСҮРЭН

Төлөвлөгөө боловсруулсан:

ХОВД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГЖИЙН ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ
(гарын үсэг)

(огноо)

ХОВД АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
-----	--	-------	------------------	--------------	-----------------------------------	-----------------------------	-------------------------

Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.

Зорилт 1.2 Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.

1.2.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэсэгжилтийн хувь	-	Цахим өгөгдөл хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б. Эрдэнэсолонго
-------	--	---	--	---	---	----------------	--

	холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.			хэрэгжүүлсэн байна.		
1.2.2	<i>БГТ 1.2.4</i> Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо		Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилсан арга хэмжээг зохион байгуулсан байна.	I-IV улирал Б.Мөнхдолгор
1.2.3	"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Журмыг хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал Б.Эрдэнэсолонго
1.2.4	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.	I-IV улирал М.Ахмарал
1.2.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусlamж,	-	-Санхүүжүүлсэн мөнгөн дүн	13019 даатгуулагчийг хамруулж 1.5 тэрбум төгрөгний	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл	I-IV улирал М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго

	үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	-Хамрагдсан даатгуулагчийн тоо	санхүүжилт олгосон	ирүүлсэн ЭМБ-үүдүүн гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.		
1.2.6	ЭМД-ын тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.	Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо	-	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	II, IV улирал	Ч.Уранчимэг Б.Мөнхдолгор

Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:

	БСТ 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо	1 санал хүргүүлсэн	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
1.4.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зөрчлийн хэргийн тоо-0 Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн-0	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор

Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөне.

Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

2.1.1	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 66. Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 48.	2023 оны хамрагдалтын хувь 66. 2023 оны хамрагдалтын хувь 48.	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 85. Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 80.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна.	I-IV улирал	Б.Мөнхдолгор
2.1.3	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.	Тевлерүүлсэн мөнгөн дүн	2023 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 99,9 хувьтай байна.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.						

2.2.1	БСТ 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	СМДС	Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	Өглөг 3,6 тэрбум, авлага байхгүй	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна	I-IV улирал	Ч.Уранчимэг Б.Мөнхдолгор
-------	---	------	-----------------------------------	----------------------------------	---	-------------	-----------------------------

Зорилго 3: Тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна

Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.

3.1.1	БСТ 3.1.2, БГТ 3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	69 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн.	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
			Гэрээний хэрэгжилтийн хувь	Гэрээний хэрэгжилт 86,7 хувь		I улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго

Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусlamж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна

3.2.1	БГТ 3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	ЭМДС	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн,	70 ЭМБ 472618 хүний 41,2 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
-------	--	------	--	---	---	-------------	---

3.2.2	БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2023 онд 5 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.	-	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	44 зөвлөмж хүргүүлсэн, хэрэгжилтийн хувь 75%.	Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор
3.2.4	БСТ 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгууллагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.	-	Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан	-	Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор

Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжине.

4.1.1	ЗГУАХ-2.1.9, БГТ 4.1.3 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан	Ахлах түшмэлийн сургалтанд 1 мэргэжилтэн, богино хугацааны сургалтанд 3 мэргэжилтэн хамрагдсан.	Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг
4.1.2	БГТ 4.1.4 Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.	-	Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан.	Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж	I-IV улирал	Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго

				мэдээлэл авсан байна.		
4.1.3	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ	Зохион байгуулсан арга хэмжээ-2, сургалтын тоо-3	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	I-IV улирал Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
4.1.4	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	18000 иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна.	185000 иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна.	I-IV улирал Ч.Уранчимэг М.Ахмарал Б.Мөнхдолгор Б.Эрдэнэсолонго
4.1.5	БГТ 4.1.8 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	480 даатгуулагч иргэн, 244 гэрээт байгууллагын эмч, ажилчид аас Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	II , IV улирал М.Ахмарал Б.Эрдэнэсолонго
4.1.6	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.	-	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо шийдвэрлэлт 104, 100 хувь.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	I-IV улирал М.Ахмарал
4.1.7	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд	Албан ажлын	Хаагчийн	Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэлийн	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын	I-IV улирал Ч.Уранчимэг

	хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	гүйцэтгэлийн төлөвлөгөөний	төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан	гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.		
4.1.8	Албан хэрэг хетлэлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.	- Бурдүүлсэн архивын нэгжийн тоо	2023 оны 12 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хетлэлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгсөн.	Албан хэрэг хетлэлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	I- улирал	М.Ахмарал
4.1.9	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана.	- Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь.	32 удаагийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт гаргаж хүргүүлсэн.	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна.	I-IV улирал	Ч.Уранчимэг Б.Эрдэнэсолонго

**ХОВД АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь						
					Эхний хагас жил	Сүүлчийн хагас жил								
Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.														
Зорилт 1.2. Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.														
1.1.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	-	Цахим өгөгдөл хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	-	Газар дээрх хяналт шалгалтыг БОЭТ, Булган НЭ, Ивээл хувийн эмнэлэг, Манхан СЭМТ, Өрх сум тосгоны нийт 25 гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хийж гүйцэтгэж улсын байцаагчийн 13 зөвлөмж, 8 албан шаардлагыг хүргүүлэн биелэлтийг хангулан, 4 удаагийн дүгнэлт, танилцуулгыг ерөнхий газарт хүргүүлэн ажилласан. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын шуурхай хурлаас өгсөн үүргийн дагуу Новартис хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа 15 ерөнхий нэршлийн 24 тун, хэмжээ бүхий эмүүдийн татан авалт, түгээлтийн судалгааг Монос, Азифарм, МЭИК 3 бөөний төвөөс авч нэгтгэхэд бөөний төвүүдэд 4113 ш эм байлаа. Мөн гэрээт 42 эмийн сангаас Новартис хөтөлбөрийн 24 тун хэмжээ бүхий эмийн нөөцийн судалгаа авч нэгтгэж ЭМДЕГ хүргүүлж ажилласан.	100%						
1.1.2	БГТ 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны		Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	-	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн		7 төрлийн 350 ш зурагт хуудсыг гэрээт 74 эрүүл мэндийн байгууллага түгээн сурталчлан ажилласан. Эрүүл мэндийн газартай хамтран гэрээт эрүүл мэндийн	100%						

	үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.			сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна.		байгууллагуудын дарга нарт ЭМДҮЗ-ийн 05,06 тогтоолоор сургалт хийж нийт 84 эмч, дарга нар хамрагдлаа мөн гэрээт 42 эмийн сангийн дарга нарт ЭМДҮЗ-ийн 11-р тогтоол, зөрчлийн тухай хуулийн холбогтох заалтыг танилцуулах сургалт хийсэн. Нийт 126 эмч, эмийн сангийн дарга нарт сургалт, мэдээлэл өгсөн.	
1.1.3	"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Журмыг хэрэгжүүлсэн байна.		Шинэчлэн баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 05, 06, 14 дугаар тогтоолуудыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажилласан.	100%
1.1.4	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавьж ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.		Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолуудыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	100%

	ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.						
1.1.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.		- Санхүүжүүл сэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагч ийн тоо	13019 даатгуул агчийг хамруулж 1.5 тэрбум төгрөгний санхүүжи лт олгосон	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-үүдийн гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж байгаа 3 эрүүл мэндийн байгууллагаас 3594 хүний 557,7 сая төгрөгний нэхэмжлэх хүлээн авч тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд системийн хяналт хийж хүний 3181 хүний 482,3 сая төгрөг олгохоор санхүүгийн хэлтэст хүргүүллээ.	100%
1.1.6	ЭМД-ын тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн		Хийсэн дүн шинжилгээнд тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо		Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас, бүтэн жилээр шинжилгээ хийж, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын саналуудыг ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.	70%

	газарт хүргүүлнэ.						
Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:							
1.4.1	БСТ 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо	1 санал хүргүүлсэн	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	-	2 удаагийн саналын төсөлд тусгах саналуудыг авч хүргүүлэн ажилласан.
1.4.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо-0 Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зөрчлийн хэргийн тоо-0 Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн-0	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	-	Прокурор, аймгийн цагдаагийн газар, Булган сумын, сум дундын цагдаагийн хэлтсээс ирүүлсэн 8 удаагийн албан бичгийн дагуу гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон 103 даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалын сангас авсан 56,361,140 мянган төгрөгийн тусlamж үйлчилгээний зардлын тооцооллыг цахим системээс нэг бүрчлэн шүүж тусlamж үйлчилгээний задаргаа тус бүрээр судалгааг гарган хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Мөн иргэний нэхэмжлэгчээр 4 удаа оролцон даатгалын санд 2 иргэний 4,740,000 төгрөгийг буцаан төлүүлэн хамтран ажилласан. Дөргөн сумын эргэлтийн эмийн сантай холбоотой зөрчлийн талаар бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авч шалгаж хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ажиллаж ЭМДС-д 10,970,579 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусlamж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.

Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусlamж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

2.1.1	ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд	2023 оны хамрагдалт ын хувь 66%	Малчдын эрүүл мэндийн	-	эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөнд 12488 даатгуулагчийг хамруулах төлөвлөгөөтэйгээс 8624	100%
-------	--	---	--------------------------------	---------------------------------	-----------------------	---	--	------

	2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖУЧ-2.2.5, МУЗГУАХ 2.1.7, БГТ 2.1.1 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	хамрагдалтын хувь		даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 85%		иргэнийг хамруулж 70%-ийн биелэлттэй байна. Үүнээс их дээд сургуулийн өдрийн ангийн суралцагч 1250 хамрагдахаас 1655 хамрагдаж 132,4%, малчин 6628 хамрагдахаас 3177 хамрагдаж 48%, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 4607 хамрагдахаас 4421 хамрагдаж 95,9% гадаадын иргэн 3 хамрагдахаас 71 хамрагдсан байна.	
	Oюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2023 оны хамрагдалтын хувь 48%	Oюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 80%				
	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2023 оны хамрагдалтын хувь 55%	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 75%				
	-Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь	2023 оны хамрагдалтын хувь 99.9%	Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100%				
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	- Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна.		Хэлтсийн 2024 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг хугацаанд нь гарган санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүллээ.	100%
2.1.3	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖУЧ-	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2023 оны орлогын төлөвлөгөөний ийн биелэлт 99,9 хувьтай байна.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний ийн биелэлтийг 100 хувь хэрэгжүүлэн		Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 10665413.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 10217443.8 мянган төгрөгийн орлого бүрдэж 2024 оны 11 сарын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 95,7%-н биелэлттэй байна. Үүнээс аж	100%

	2.2.5, МУЗГУАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангулж, тайлагнана.			ажилласан байна.		ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 910400.7 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 770143.8 мянган төгрөгийн орлого бүрдэж 84,5% биелсэн, ажил олгогчийн эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 9755012.3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 9447300.0 мянган төгрөгийн орлого бүрдэж 96,8%-н биелэлттэй, тэр хариуцах иргэдийн шимтгэлийн орлого 8654407.7 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 673688.4 мянган төгрөгийн орлого бүрдэж 7,8%-н биелэлттэй байна.	
--	---	--	--	---------------------	--	---	--

Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.

2.2.1	БСТ 2.2.1, БГТ- 2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	ЭМДС	Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	Өглөг тэрбум, авлага байхгүй	3,1 Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна	-	Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлд сар бүрт хяналт тавьж ажилласан. 3,6 тэрбум төгрөгийн өглөгтэй.	100%
-------	--	------	---	---------------------------------------	--	---	--	------

Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна

Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэлгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.

3.1.1	БСТ 3.1.2, БГТ 3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн		Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	69 гэрээт эрүүл мэндийн байгууллагы г дүгнэсэн.	Гэрээт ЭМБ- уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний	-	Тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлтийг А/61 тушаалын дагуу үнэлэхэд лавлагаа шатлалын 8 эрүүл мэндийн байгууллага 89-95%, анхан шатны 21 эрүүл мэндийн төвүүдийг үнэлэхэд 5 өрхийн эрүүл мэндийн төв 90-97%, 7 сумын эрүүл мэндийн төв 80-86%, 7 сумын эрүүл мэндийн төв 74-79%, 1 сум, 1 өрх 65-	100%
			Гэрээний хэрэгжилтийн хувь	Гэрээний хэрэгжилтийн хувь				

	сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.			саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.		69% дүгнүүлж хангалтгүй дүгнүүлсэн 2 газарт албан шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан 41 эмийн сангуудын гэрээний биелэлтийг дүгнэхэд дундаж үнэлгээ нь 88,3 хувтай үнэлэгдсэн 1 эмийн сан нь 90 дээш, 34 эмийн сан нь 80-89,9, 6 эмийн сан нь 60-79,9 оноотойгоор тус тус үнэлэгдсэн, гэрээгээ дүгнүүлээгүй 1, хангалтгүй дүгнүүлсэн 2 эмийн сангуудад албан шаардлага хүргүүлж эрхийг нь түр хаалган, биелэлтийг дахин үнэлж ерөнхий газарт дотоод албан бичиг хүргүүлэн хөнгөлөлттэй жор олгож ажиллах эрхийг нээлгэж ажилласан.		
Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусlamж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна								
3.2.1	БГТ 3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид сууриссан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	ЭМДС	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мэнгэн дүн,	70 ЭМБ 472618 хүний 41,2 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянацсан.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	-	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын эхний 10 сарын байдлаар 1370 нэхэмжлэлийг сар бүрийн эхний 5 хоногт цахим хаягаар тулган хүлээн авч, гэрээ бүхий 74 эрүүл мэндийн байгууллагуудаас 40,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авч чанар төлбөрийн хяналтаар 9024 хүний 4,4 тэрбум төгрөг хасаж 39,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн хэлтэст хянаж хүргүүлсэн. Хэлтсийн 4 мэргэжилтэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас түүвэрлэгдсэн 438 эрүүл мэндийн байгууллагын 25245 түүвэрт нарийвчилсан хяналт хийж 5727 хүний 3,3 тэрбум төгрөгний хасалт хийж ажиллаа.	100%
3.2.2	БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн	2023 онд 5 ЭМБ-д зөвлөн	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 1-2 удаа тусlamж үйлчилгээний нэхэмжлэлд хяналт хийж хяналтаар	100%	

	байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.		байгууллагын тоо	туслах үйлчилгээ үзүүлсэн.	зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.		хасагдсан түүврүүдэд шинжилгээ хийж зөвлөмж хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж тухай бүр зөвлөмжүүд, албан шаардлагууд, танилцуулгууд хүргүүлэн ажилласан.	
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусlamж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.	-	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	44 зөвлөмж хүргүүлсэн, хэрэгжилтийн хувь 75%	Тусlamж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.		Нэхэмжлэлийн хяналтын явцад хяналтын шалгуур хангаагүй улсын 2, хувийн хэвшлийн 6 эмнэлгүүд зөвлөмжүүд, эмийн сангийн гэрээ дүгнэхэд 70%-тай үнэлэгдсэн 2 эмийн сангудад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.	100%
3.2.4	БСТ 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.	-	Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан	-	Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.		Газар дээрх хяналт шалгалтыг БОЭТ, Булган НЭ, Ивээл хувийн эмнэлэг, Манхан СЭМТ, Өрх сум тосгоны нийт 25 гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хийж гүйцэтгэж улсын байцаагчийн 13 зөвлөмж, 8 албан шаардлагыг хүргүүлэн биелэлтийг хангуулан дүгнэлт, танилцуултыг ерөнхий газарт хүргүүлэн ажилласан..	100%
Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.								
Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжине.								
4.1.1	ЗГУАХ-2.1.9, БГТ 4.1.3	-	Авч хэрэгжүүлсэн	Ахлах түшмэлийн сургалтанд 1	Арга хэмжээ авч		Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан 7 удаагийн сургалт, нийтийн биеийн тамир аймгийн	100%

	Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.		арга хэмжээний тоо, тайлан	мэргэжилтэн , богино хугацааны сургалтанд 3 мэргэжилтэн хамрагдсан	хэрэгжүүлсэн байна.		хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн сургалт болон зохион байгуулсан нийтийн биесийн тамир спортын сорил, арга хэмжээнд тус тус хамрагдаж ,	
4.1.2	БГТ 4.1.4 Ерөнхий газраас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.	-	Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан.	Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна.		Ерөнхий газраас цахимаар зохион байгуулсан 19, ТА3-еөс зохион байгуулсан 20 удаагийн вебинар онлайн болон танхимины сургалтууд, агентлагаас зохион байгуулсан мэдээллийн цагийн хөтөлбөрт 9 удаа, Удирдах ажилтын зөвлөгөөн, Орон нутаг дахь удирдах албан тушаалтнуудын сургалт тус тус бүрэн хамрагдсан	100%
4.1.3	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ-17	Зохион байгуулсан арга хэмжээ-2, сургалтын тоо-3	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.		Тус хэлтэс дээр ирж үйлчлүүлсэн 636 иргэдэд мэдээлэл өгч үүнээс 236 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг Е-баримт аппликашн ашиглан төлүүлсэн. Аймгийн төрийн байгууллагууд хамтран зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа өдөрлөгт 2 өдөр оролцож иргэн даатгалуулагчдад эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, шимтгэл төлөлтийн мэдээллээ шалгах, Е-Баримт ашиглан эрүүл мэндийн даатгал төлөх, эмийн үнийн хөнгөлөлт зэрэг мэдээллийг 102 иргэнд хүргэсэн. Аймгийн удирдах ажилтаны зөвлөгөөн, сургалт 28 иргэний даатгал төлүүлж ажилласан.	100%

4.1.4	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	18000 иргэн даатгуулагч дад мэдээлэл хүргэсэн байна.	185000 иргэн даатгуулагчда д мэдээлэл хүргэсэн байна.		Төр хариуцах иргэдийн шимтгэл төлөлт, хугацааг цахим системд бүртгэх ажлын хурээнд нийт 56 иргэний ногдуулалтыг мэдээллийн санд бүртгэж, шинээр төрсөн 13 хүүхдийн бүртгэлийг үүсгэж ажилласан. Хэлтэс дээр ирж үйлчлүүлсэн 415 иргэний шимтгэл төлөлтийг шалгаж, э-баримт ашиглан 236 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлсэн. Хэлтсийн пэйж хуудас 1101 дагагчтай болж 277 дагач нэмэгдүүлсэн ерөнхий газрын пэйж хуудсанд тавигдсан 730 мэдээллүүдийг хэлтсийнхээ пэйж хуудас байршуулж 471047 иргэнд түгээсэн, хэлтсээс 10 контент мэдээллүүдийг бэлтгэж пэйж хуудсанд байршуулан 15430 иргэнд хүргэсэн	100%
4.1.5	БГТ 4.1.8 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	480 даатгуулагч иргэн, 244 гэрээт байгууллагын эмч, ажилчидас Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.		Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас 112 иргэн даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тус тус авч дүн шинжилгээ хийж ажилласан. Ерөнхий газраас сонгогдож ирсэн ирсэн нэрсийн дагуу 7 эрүүл мэндийн байгууллагуудад судалгааны линк хүргүүлж судалгааг авсан	100%
4.1.6	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	-	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 104, шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн		Жилийн хугацаанд хэлтэст ирсэн иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ буруу төлсөн 32 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч эрүүл мэндийн даатгалын ерөнхий info@emd.gov.mn хаяг руу тухай бүр	100%


	зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлagnана.			жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.		хүргүүлсэн. Хурууны хээтэй холбоотой 35, регистрийн дугаар нь зөрчилтэй шинэ регистрийн дугаар дээр шимтгэл төлөлт харагдахгүй байгаа шалтгаанаар эрүүл мэндийн байгууллагаас тусlamж үйлчилгээ авч чадахгүй байгаа 6 нийт 41 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох материалын хамт дотоод албан бичиг боловсруулан ерөнхий газрын тамгын газарт тус тус хүргүүлэн ажилласан.	
4.1.7	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Хэлтсийн мэргэжилтэн ийг гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	Хэлтсийн чанар төлбөрийн хяналтын З мэргэжилтний 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж төлөвлөгөөний биелэлтийг оны эхнээс жигд ханганд биелүүлэхэд зөвлөн ажиллаж мөн хэлтсийн хийж гүйцэтгэх ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжилтнүүдэд хувиарлаж ажлын ачааллыг тэнцүүлэн өдөр тутмын удирдлагаар ханганд ажиллаж байна.	100%
4.1.8	Албан хэрэг хетлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.	-	Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо	2023 оны 12 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хетлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн	Албан хэрэг хетлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	Хэлтэст ирсэн, явсан бичиг, дотоод албан бичиг нийт 141 албан бичгийг хүлээн авч тухай бүр бүртгэлжүүлэн хөтөлж албан бичгийн хариуг хугацаанд нь хүргэж ажилласан. 2023 оны гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын анхан шатны баримтуудыг архивын 18 боть үүсгэж архивласан.	100%

				ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн				
4.1.9	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь.	32 удаагийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт гаргаж хүргүүлсэн.	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна.		Шуурхай хурлаас өгөгдсөн байнга хэрэгжүүлэх үүрэг даалгаврын биелэлт 26, шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт 17 удаа гарган хэлтсийн даргаар хянуулж ерөнхий газарт хүргүүлсэн. Хэлтсийн 7 хоногийн ажлын мэдээг нэгтгэн 21 удаа гаргаж бэлдсэн.	100%

Төлөвлөгөөг үнэлсэн:
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ ТАМГИЙН ГАЗРЫН ДАРГА**

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн:
**ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА**

Тайлагнасан:
**ХОВД АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Төсвийн шууд захирагч

(М. НАРМАНДАХ)
2024.10.16.... (огноо)

Нэгжийн дарга

(Б. ОЮУНЦЭЦЭГ)
..... (огноо)

Нэгжийн дарга

(М. ЦЭВЭЭНСҮРЭН)
2024.10.16.... (огноо)